

УЛААНБААТАР ХОТЫН ХҮЙТНИЙ УЛИРЛЫН АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ /2024 ОНЫ 02 ДУГААР САР/

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна.


2024 оны хүйтний улирал 02 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад PM_{10} тоосонцор 12 мкг/м^3 -ээр буюу 10%-иар бага, харин $\text{PM}_{2.5}$ тоосонцор 11 мкг/м^3 -ээр буюу 16%-иар, азотын давхар исэл (NO_2) нь 5 мкг/м^3 -ээр буюу 8%-иар, хүхэрлэг хий (SO_2) нь 6 мкг/м^3 -ээр буюу 5%-иар тус тус их байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м^3	
	Хүлцэх агууламж, мкг/м^3	2023 оны 02 дугаар сар	2024 оны 02 дугаар сар
$\text{PM}_{2.5}$ тоосонцор	50	70	81 ↑
PM_{10} тоосонцор	100	116	104 ↓
Азотын давхар исэл, NO_2	50	60	65 ↔
Хүхэрлэг хий, SO_2	50	111	117 ↑

* ↓ бага; ↑ их; ↔ ойролцоо түвшинд $\pm 5\%$.

Улаанбаатар хотын сүүлийн 6 жилийн хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.


PM_{2.5} тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын $\text{PM}_{2.5}$ тоосонцрын сарын дундаж агууламж, 2019-2024 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 11 мкг/м³-ээр буюу 16%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 31 мкг/м³-ээр их байна (Зураг 1).


PM10 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2019-2024 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 12 мкг/м³-ээр буюу 10%-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 4 мкг/м³-ээр их байна (Зураг 2).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2019-2024 он

Азотын давхар ислийн (NO₂) 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 5 мкг/м³-ээр буюу 8%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 15 мкг/м³-ээр их байна (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO₂)




Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2019-2024 он

Агаар дахь хүхэрлэг хийн (SO₂) 2024 оны 02 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 6 мкг/м³-ээр буюу 5%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 67 мкг/м³-ээр их байна (Зураг 4).

УЛААНБААТАР ХОТЫН 2024 ОНЫ 02 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ /2023 ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАВ/

№	Цаг уурын үзүүлэлт	2023 оны 02 дугаар сарын дундаж	2024 оны 02 дугаар сарын дундаж
1	Агаарын дундаж температур °C	-13.3 °C	-18.7 °C
2	Салхины дундаж хурд, м/с	1.7 м/с	1.7 м/с
3	Сарын нийлбэр хур тунадас, мм	0.0 мм	2.9 мм

2024 ОНЫ 02 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКС
/АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРУУЛ ТУС БҮРЭЭР ҮЗҮҮЛЭВ/



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС